

## **2018 ОНЫ 5 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 8 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ, УАУТ/ мэдээ ирүүлсэн.

**Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:**

2018 оны 5 дугаар сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас УНТЭ, УХТЭ, ХСҮТ-ийн амбулаторийн үзлэг хүлээгдэлтэй ажилласан бол УГТЭ-ийн амбулаторийн кабинетүүдэд хүлээгдэл буурсан ба тусламж үйлчилгээг өдөрт нь үзүүлсэн байна.

УНТЭ-ийн амбулаторийн 11 кабинетэд нийт 171 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж өмнөх сарын хүлээгдлээс 238 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнээс: Бөөрний кабинетэд 1 үйлчлүүлэгч, зүрх судасны кабинетэд 11 үйлчлүүлэгч, уушигны кабинетэд 3 үйлчлүүлэгч, мэс заслын кабинетэд 1 үйлчлүүлэгч, нүдний даралтын кабинет 13 үйлчлүүлэгч, чих хамар хоолой 12 үйлчлүүлэгч, мэдрэл судлалын кабинетэд 35 үйлчлүүлэгч, урологийн кабинет 21 үйлчлүүлэгч, хоол боловсруулах эрхтэн судлал 45 үйлчлүүлэгч, үений мэс засал 28 үйлчлүүлэгч, цус судлалын кабинет 1 үйлчлүүлэгч тус бүр 1-6 хоногийн хугацаатай хүлээгдэлд бүртгэгджээ. 11 кабинет хүлээгдэлгүй ажиллаж байна.

УХТЭ-т нийт 10 кабинетэд 156 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Амбулаторийн хүлээгдэл өнгөрсөн сард 10 кабинетэд нийт 242 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 86 үйлчлүүлэгчээр буурсан байна.


Үүнд: Бөөр судлалын кабинетэд 11, зүрх судасны кабинетэд 15 үйлчлүүлэгч, мэдрэл судлал 42 үйлчлүүлэгч 1-3 хоногийн хүлээгдэлтэй, нүдний кабинет 8 үйлчлүүлэгч, хоол боловсруулах эрхтэн судлал 50 үйлчлүүлэгч, чих хамар хоолойн кабинетэд 3 үйлчлүүлэгч 1-2 хоног, булчирхайн кабинетэд 8 үйлчлүүлэгч, эмэгтэйчүүдийн кабинет 13 үйлчлүүлэгч тус тус 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. 225 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т 2 кабинетэд 61 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Зүрх судасны кабинетэд 25 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 24 үйлчлүүлэгчээр буурсан, мэдрэлийн кабинетэд 36 үйлчлүүлэгч хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. 15 кабинет хүлээгдэлгүй, өдөртөө үйлчлүүлсэн 15 кабинетэд 442 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ХСҮТ-ийн амбулаторийн 11 кабинетэд нийт 105 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 17 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнээс: элэг цэс нойр булчирхай 11 үйлчлүүлэгч, хими эмчилгээний кабинет 2 үйлчлүүлэгч, цээжний хөндийн мэс засалд 14 үйлчлүүлэгч, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинетэд 20 үйлчлүүлэгч, ерөнхий мэс заслын кабинет 5 үйлчлүүлэгч, толгой хүзүүний мэс заслын кабинетэд 2, туяа эмчилгээний кабинетэд 6 үйлчлүүлэгч, хөнгөвчлөх эмчилгээнд 3, гепатологийн кабинет 3, ангиографийн кабинетэд 2 үйлчлүүлэгч тус бүр 1-7 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 42 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

/ Амбулаторит хүлээгдэж буй үйлчлүүлэгчдийн тоо нь ХСҮТ-н амбулаторит тухайн өдөр анх удаа үзүүлэхээр ирсэн үйлчлүүлэгчдийн мэдээлэлд үндэслэн хүлээгдлийн мэдээг гаргав/

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн 5-р сарын амбулаторийн хүлээгдлийг  
үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



**Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:**

2018 оны 5 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, СЭМУТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн рентген 187 үйлчлүүлэгч 1-14 хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 34 үйлчлүүлэгчээр буурсан байна. Хэвлийн эхо 66 үйлчлүүлэгч 3-6 хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 225 үйлчлүүлэгчээр буурсан байна. Зүрхний цахилгаан бичлэг 11 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Тархины цахилгаан бичлэг хийлгэхээр 8 үйлчлүүлэгч 2 хоног хүлээж үйлчлүүлжээ. MRI шинжилгээ 11 үйлчлүүлэгч 3-6 хоног, захын судасны ЭХО 22 үйлчлүүлэгч, радиоимунологи 80 үйлчлүүлэгч, КТГ 15 үйлчлүүлэгч 2-14 хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.


УХТЭ-т рентген зураг авахуулахаар 75 үйлчлүүлэгч 1-14 хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 4 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Хэвлийн эхо 75 үйлчлүүлэгч хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 16 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 16 үйлчлүүлэгч хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 36 үйлчлүүлэгчээр буурсан, захын судасны ЭХО 16 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т доплерграфийн шинжилгээнд 9, зүрхний эход харуулахаар 4 үйлчлүүлэгч, рентген 17 үйлчлүүлэгч, зүрхний цахилгаан бичлэг 63 үйлчлүүлэгч, хэвлийн ЭХО 56 үйлчлүүлэгч, тархины цахилгаан бичлэг 7 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.


ХСҮТ-д анх удаа үзүүлэхээр дугаар авсан 177 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 78 үйлчлүүлэгч, 1-7 хоногийн хүлээгдэлтэй 12 үйлчлүүлэгч байна. үүнд: бүдүүн шулуун гэдэсний дуран 4, ходоодны дуран 32, хэвлийн ЭХО 63 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

СЭМУТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 296 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 122 өдөртөө, 31 үйлчлүүлэгч 1 хоног, 35 үйлчлүүлэгч 2 хоног, 72 үйлчлүүлэгч 3-6 хоног, 36 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн оношлогооны кабинетийн 5-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээний 3, 4, 5-р сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/



**Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:**


2018 оны 5 дугаар сард УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 584 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: цусны ерөнхий шинжилгээ 42, шээсний ерөнхий шинжилгээ 51, биохимийн шинжилгээ 354, бактериологийн шинжилгээ 45, иммунологийн шинжилгээ 75, коагулаграммын шинжилгээ 10, ДОХ/сериологи 4, цитологи 3 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 413 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 425 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: цусны ерөнхий шинжилгээ 79, шээсний ерөнхий шинжилгээ хүлээгдэлгүй, биохимийн шинжилгээ 102 үйлчлүүлэгч, бактериологи иммунолог, серологи, цитологи хүлээгдэлгүй, коагулограммын шинжилгээ 20 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 224 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ-д лабораторийн хүлээгдэлгүй байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 5-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



**Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

2018 оны 5 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, УАУТХ, СЭМҮТ бүртгэн мэдээлсэн.

УНТЭ-т 5-р сард нийт 11 үйлчлүүлэгч 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Урологийн тасагт нийт 7 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй байгаагаас 5 үйлчлүүлэгч 1-3 хоног, 2 үйлчлүүлэгч 7-14 хоног, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 4 үйлчлүүлэгч хүлээгдэлтэй байгаагаас 3 үйлчлүүлэгч 1-3 хоног, 1 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т 5-р сард 221 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр 1-14 хүртэл хоногийн хугацаанд хүлээсэн байна. Үүнд: Бөөр судлалын тасагт 10 үйлчлүүлэгч, зүрх судасны тасаг 35 үйлчлүүлэгч, уушигны тасаг 37 үйлчлүүлэгч, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 27 үйлчлүүлэгч, мэс засал 87 үйлчлүүлэгч, мэдрэлийн тасагт 8 үйлчлүүлэгч, уламжлалт эмчилгээний тасагт 17 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т 5-р сард нийт 95 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: мэдрэлийн мэс засалд 40 үйлчлүүлэгч 1-30 хоног, зүрх судасны тасагт 19 үйлчлүүлэгч, бөөр судлалын тасагт 3 үйлчлүүлэгч, уушигны тасагт 15 үйлчлүүлэгч, мэдрэлийн тасаг 9 үйлчлүүлэгч тус тус 1-14 хоногийн хугацаанд, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 2 үйлчлүүлэгч, уламжлалтын тасагт 7 үйлчлүүлэгч 1-3 хоног, чих хамар хоолойн тасагт 10 үйлчлүүлэгч 15-30 хоног, тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

ЭХЭМҮТ-ийн эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 46 үйлчлүүлэгч 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн.


ХСҮТ-д 5-р сард нийт 13 тасагт 48 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд: 1-3 хоногийн хугацаанд 24 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 9 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 6 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 5 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 4 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг. Хэвтэх яаралтай шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг. Өдрийн химийн 1 ор дээр өдөрт 2-3 өвчтөн хэвтэн нийт өдөрт 35-40 өвчтөн 2-5 хоногийн давтамжтай эмчлэгддэг, Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна. Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

УАУТХ-д уламжлалт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 8 үйлчлүүлэгч, 7-14 хоног 52 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хугацаанд 93 үйлчлүүлэгч буюу нийт 153 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 25 үйлчлүүлэгч, 39 үйлчлүүлэгч 3-6 хоног, 98 үйлчлүүлэгч 7-14 хоног, 12 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хугацаанд нийт 174 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

Сүүлийн 6 сарын хугацаанд СЭМҮТ-ийн неврозын тасагт хэвтэн эмчлэхээр бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн хүлээгдэл /тоогоор/



**Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

НЭМГ-ын харъяа 8 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн мэдрэл, Налайх

дүүргийн дотор, Сонгинохайрхан дүүргийн дотор, Чингэлтэй дүүргийн дотор, Наркологийн төв тус бүр 15-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 5-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

**Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 5 сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ**

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн эмнэлэг
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	90	5	7	7	21	21	0	0	0	0	0
		1-3 хоног			5	3		3					
		3-6 хоног		5	2		2	6					
		7-14хоног	15			4	2	11					
		15-30 хоног	28				17	1					
		1 сараас дээш	47										
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	188	49	91	55	0	35	4	0	0	0	0
		1-3 хоног		17	46	10		4	4				
		3-6 хоног		12	22	9		1					
		7-14хоног	18	16	15	15		30					
		15-30 хоног	143	4	8	21							
		1 сараас дээш	27										
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	51	0	0	0	0	20	0	0	0	0	0
		1-3 хоног	13					8					
		3-6 хоног	13					7					
		7-14хоног	25					5					
		15-30 хоног											
		1 сараас дээш											
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	12	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног				3							
		3-6 хоног				5							
		7-14хоног				4							
		15-30 хоног											
		1 сараас дээш											
6	Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											
		3-6 хоног											

		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
7	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	163
		1-3 хоног											39
		3-6 хоног											78
		7-14хоног											37
		15-30 хоног											7
		1 сараас дээш											2


Нийслэлийн түргэн тусламжийн төвд 4 дүгээр сард 21416 дуудлага бүртгэгдсэний 40.3 %-ийг 0-20 минутад, 22.2 %-ийг 21-40 минутад, 21.3 %-ийг 41-60 минутад, 16.2 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 1,2, 3, 4, 5 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/


**Нийслэлийн түргэн тусламжийн төвийн тусламж үйлчилгээний 2018 оны 1-5 сарын хүлээгдлийн мэдээ**

№	Үзүүлэлт	1 сар		2 сар		3 сар		4 сар		5 сар		
		Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь	
1	Нийт дуудлага	28630	100%	23553	100%	25567	100%	21416	100%	23191	100%	
2	Хүлээгдлийн минут	0-20 минут	9248	32.3%	7949	33.7%	8850	34.6%	8637	40.3%	9588	41.3%
3		21-40 минут	8678	30.3%	7603	32.3%	8637	33.8%	4756	22.2%	7328	31.6%
4		41-60 минут	5361	18.7%	4310	18.3%	4870	19.0%	4550	21.3%	3499	15.1%
5		1 цагаас дээш	5343	18.7%	3691	15.7%	3210	12.6%	3473	16.2%	2776	12.0%

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн тусламж үйлчилгээний 2018 оны сүүлийн 3 сарын хүлээгдлийн мэдээг графикаар харуулахад:



Нийслэлийн түргэн тусламжийн төвд  
2018 оны эхний 5 сарын хугацаанд ирсэн нийт дуудлагын тоо:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА